



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2022 оны 11 сарын 30 өдөр

Дугаар A/24

Улаанбаатар хот

Г Нийцлийн аудитын тайланг  
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/12 дугаар тушаал, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Нийслэлийн сургууль, цэцэрлэгүүдэд хүнс, хангамжийн материал нийлүүлдэг ОНӨААТҮГ-уудын шилэн данс, худалдан авах ажиллагаа”-нд хийсэн нийцлийн аудитын /НАГ-2022/26/01-ШТА-НА/ тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2023 оны 4 дүгээр улиралд гаргаж танилцуулахыг Аудитын удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Бат-Өлзий)-т үүрэг болгосугай.

3. Тайланг Үндэсний аудитын газар, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газар, Хүнс, хангамжийн материал нийлүүлдэг ОНӨААТҮГ-уудад тус тус хүргүүлсүгэй.



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

002010101



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

НИЙСЛЭЛИЙН СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГҮҮДЭД ХҮНС, ХАНГАМЖИЙН  
МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛДЭГ ОНӨААТУГ-УУДЫН ШИЛЭН ДАНС,  
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

АУДИТЫН КОД: НАГ-2022/26/01-ШТА-НА

---

АУДИТЫН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН  
ХЭЛТЭС

Хэлтсийн дарга, аудитын менежер  
Ц.Бат-Өлзий  
Аудитын багийн ахлагч, аудитор У.Оюунхүү  
Аудитор С.Лхагвасүрэн, Э.Дөлгөөн

Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө Г корпус  
425 дугаар өрөө. Утас: 11315578

---

Улаанбаатар хот  
2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой  
мэдээллийг дараах хаягаар авна уу.  
Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

---



## АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР .....	3
АУДИТЫН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ .....	4
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх.....	4
Аудитын зорилт .....	4
Аудитын хамарсан хүрээ .....	4
Аудитын арга зүй, стандартын талаарх мэдэгдэл .....	4
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд.....	4
Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн .....	5
БҮЛЭГ 1. ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДСАНД БАЙРШУУЛБАЛ ЗОХИХ МЭДЭЭЛЛИЙГ ХУГАЦААНД НЬ БҮРЭН МЭДЭЭЛСЭН ЭСЭХ .....	6
БҮЛЭГ 2. ХҮНС, ХАНГАМЖИЙН МАТЕРИАЛЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН ЭСЭХ.....	8
СУРГУУЛЬ ЦЭЦЭРЛЭГҮҮДЭД НИЙЛҮҮЛЖ БУЙ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЭС ӨНДӨР БАЙГАА ЭСЭХ.....	12
АУДИТЫН ДҮГНЭЛТ.....	16
АУДИТЫН ЗӨВЛӨМЖ .....	17
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДААС ИРҮҮЛСЭН САНАЛ .....	18
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГӨХ ХАРИУ ТАЙЛБАР .....	20
Хавсралт 1 .....	22



## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
НӨАУГ	Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газар
НӨАТ	Нэмэгдсэн өргтийн албан татвар



## АУДИТЫН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

### Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны A/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, “Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх аудитын төлөвлөгөө”-д үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн 2022 оны 01/1567 тоот албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу хийж гүйцэтгэв.

### Аудитын зорилт

Нийслэлд үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчийн сургууль, цэцэрлэгүүдэд хүнс, хангамжийн материал нийлүүлдэг ОНӨААТҮГ-уудын шилэн дансны үйл ажиллагаанд аудит хийж худалдан авах ажиллагаатай холбоотой эрсдэл бүхий асуудалд нарийвчилсан бодит цагийн хяналтыг хэрэгжүүлэн, дүнг холбогдох албан тушаалтанд хүргүүлэх зорилгоор аудитыг хийж гүйцэтгэсэн. Энэхүү зорилтын хүрээнд аудитыг дараах дэд асуудлуудад чиглүүлэн ажилласан. Үүнд:

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх;
2. Хүнс, хангамжийн материалын худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан эсэх.

### Аудитын хамарсан хүрээ

“Асгат”, “Багачууд хүнс”, “Хүнс хангамж”, “Өсвөр үе хүнс”, “Налайх хангамжийн төв” ОНӨААТҮГ-ын шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээлэл, зохион байгуулсан худалдан авах ажиллагаа, худалдан авсан болон сургууль, цэцэрлэгүүдэд нийлүүлсэн хүнсний бүтээгдэхүүний 2022 оны үнийн судалгааг хамруулан аудит хийсэн.

### Аудитын арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитыг Төрийн аудитын “Тулгуур зарчим” MNS6817-1:2020, “Нийцлийн аудитын зарчим” MNS6817-6:2020, “Нийцлийн аудитын заавар, аргачлал”, “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд аудит хийх аргачлал”-ыг баримтлан хийж гүйцэтгэсэн.

Төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулбал зохих мэдээллийг мэдээлсэн эсэхийг харилцах дансны гүйлгээ, тушаал шийдвэр, холбогдох мэдээлэлтэй тулган шалгах, худалдан авах ажиллагаанаас түүвэрлэн хуулийн дагуу зохион байгуулсан эсэхийг хууль тогтоомж, заавар журамтай харьцуулан дун шинжилгээ хийх, нийлүүлж буй бүтээгдэхүүний үнийг зах зээлийн үнэтэй харьцуулсан судалгаа хийх зэрэг арга зүй, аудитын горимыг хэрэгжүүлж нотлох зүйл цуглуулан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан.

### Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд

Аудитад Нийтийн мэдээллийн ил тод байдлын, Шилэн дансны, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Засгийн газрын 2015 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”, “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 2021 оны 124-р тогтоол, Сангийн сайдын баталсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн



сан бүрдүүлэх журам", "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам", "Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам", Тендерийн жишиг баримт бичиг баталсан тушаалууд болон холбогдох бусад хууль тогтоомж, заавар, журмуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

### **Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн**

Аудитыг Нийслэл дэх Төрийн аудитын газрын Аудитын удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга, аудитын менежер Ц.Бат-Өлзий хянан удирдаж, аудитор У.Оюунхүү ахлан аудитор С.Лхагвасүрэн, Э.Дөлгөөн нарын хамт 2022 оны 9 дүгээр сарын 26-аас 11 дүгээр сарын 30-н хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.



## БҮЛЭГ 1. ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДСАНД БАЙРШУУЛБАЛ ЗОХИХ МЭДЭЭЛЛИЙГ ХУГАЦААНД НЬ БҮРЭН МЭДЭЭЛСЭН ЭСЭХ

### Ерөнхий мэдээлэл

Шилэн дансны тухай хуульд зааснаар ОНӨААТҮГ-ууд нь зорилтот түвшин, түүний гүйцэтгэл, таван сая төгрөгөөс дээш худалдан авалт, орлого, зарлагын гүйлгээ, төсөв, өмч хөрөнгө зарцуулах шийдвэр, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, төсвийн төсөл, тендерийн мэдээлэл зэргийг шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй.

#### 1.1. Шилэн дансанд байршуулбал зохих мэдээллийг бүрэн мэдээлсэн үү?

Нийслэлд үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчийн сургууль, цэцэрлэгүүдэд хүнс, хангамжийн материал нийлүүлдэг ОНӨААТҮГ-ууд 2022 оны эхний 9 сарын байдлаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийтдээ 1522 мэдээлэл байршуулахаас 1488 буюу 97.8%-ийг мэдээлжээ.

Шилэн дансанд байршуулах мэдээллийг мэдээлсэн байдал

№	ОНӨААТҮГ-ЫН НЭР	Мэдээлбэл зохих	ҮНЭЭС МЭДЭЭЛСЭН		Мэдээлээгүй
			Тоо	Хувь	
1	Асгат	222	220	99.1%	2
2	Багачууд хүнс	328	325	99.1%	3
3	Өсвөр үе хүнс	449	444	98.9%	5
4	Хүнс хангамж	370	364	98.4%	6
5	Налайх хангамжийн төв	153	135	88.2%	18
Нийт		1522	1488	97.8%	34

Асгат, Багачууд хүнс, Өсвөр үе хүнс, Хүнс хангамж гэсэн 4 газрын хувьд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэл байршуулах чиг үүргийн хэрэгжилт 98.4-99.1%-тай сайн байгаа бөгөөд бусадтайгаа харьцуулахад Налайх хангамжийн төвийн хувьд хэрэгжилт харьцангуй бага ч 88.2%-тай байна.

Засгийн газрын 2016 оны 29 дугаар тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-д заасныг зөрчин шилэн дансанд байршуулаагүй 34 мэдээллийн дийлэнх хувийг төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэр болон таван сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээг мэдээлээгүй зөрчил эзэлж байна. Үүнд:

- Налайх хангамжийн төв 8, Хүнс хангамж 4, Өсвөр үе хүнс 3, Багачууд хүнс 2, нийтдээ төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 17 шийдвэрийг мэдээлээгүй нь журмын 4.1.10<sup>1</sup>;
- Налайх хангамжийн төв 9, Хүнс хангамж 1, нийтдээ таван сая төгрөгөөс дээш орлого, зарлагын 10 гүйлгээг мэдээлээгүй нь журмын 4.1.9<sup>2</sup>;
- Асгат, Хүнс хангамж, Багачууд хүнс ОНӨААТҮГ-ууд тендер сонгон шалгаруулах, гэрээ байгуулах шийдвэр гаргахдаа ашиг сонирхлын зөрчилгүй талаарх мэдүүлгийг шилэн дансанд мэдээлээгүй нь журмын 4.1.17<sup>3</sup>;
- Асгат, Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ дараа жилийн төсвийн төслийг, Налайх хангамжийн төв ОНӨААТҮГ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг, Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 1

<sup>1</sup> 4.1.10. “... төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг ... 7 хоногийн дотор”;

<sup>2</sup> 4.1.9. “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дун бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ хийгдсэнээс хойш зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбарын хамт 7 хоногийн дотор ...”;

<sup>3</sup> 4.1.17. “Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг тухай бүр PDF форматаар”;



мэдээллийг шилэн дансанд байршуулаагүй нь журмын 4.1.1<sup>4</sup>, 4.1.8<sup>5</sup>, 4.1.13<sup>6</sup> дахь заалтыг тус тус зөрчжээ.

“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 4.1.9-т “... таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг ... зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбарын хамт” мэдээлэхээр заасан ч хүнс, хангамжийн материал нийлүүлдэг ОНӨААТҮГ-ууд зарлагын гүйлгээнд холбогдох шийдвэрийг хавсаргаагүй зөрчил нийтлэг байна.

## 1.2. Шилэн дансанд мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь байршуулсан уу?

Хүнс, хангамжийн материал нийлүүлдэг ОНӨААТҮГ-ууд 2022 онд шилэн дансанд байршуулсан 1488 мэдээллийн 1471 буюу 98.9%-ийг хугацаанд нь, 17 мэдээлэл буюу 1.1%-ийг хугацаа хоцроож мэдээлжээ. Хугацаа хоцроож мэдээлсэн мэдээллийг байгууллагаар авч үзвэл Налайх хангамжийн төв 8, Асгат 6, Багачууд хүнс 2, Хүнс хангамж 1, нийт 4 байгууллага 17 мэдээллийг хугацаа хоцроожжээ.



Хүнс, хангамжийн материал нийлүүлдэг ОНӨААТҮГ-ууд шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллийн 97.8%-ийг мэдээлж, үүнээс 98.9%-ийг хугацаанд нь байршуулжээ.

<sup>4</sup> 4.1.1. “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор”;

<sup>5</sup> 4.1.8. “Таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалтын мэдээг гэрээ, хэлцэл, санхүүжилт өгснөөс 7 хоногийн дотор”

<sup>6</sup> 4.1.3. “Дараа жилийн зорилтот түвшнийг жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор PDF форматаар”;



## БҮЛЭГ 2. ХҮНС, ХАНГАМЖИЙН МАТЕРИАЛЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН ЭСЭХ

### Ерөнхий мэдээлэл

Худалдан авах ажиллагааг Налайх хангамжийн төв ОНӨААТҮГ хичээлийн жилээр буюу 2021 оны 9 дүгээр сараас 2022 оны 6 дугаар сар дуусталх хугацаанд нийлүүлэх хүнсний бүтээгдэхүүнээр, бусад ОНӨААТҮГ-үүд нь төсвийн жилээр буюу 2022 оны 1 дүгээр сараас 12 дугаар сард нийлүүлэх хүнсний бүтээгдэхүүнийг худалдан авахаар сонгон шалгаруулалт зарлажээ.

### 2.1. Үнэлгээний хороог хуулийн дагуу зохион байгуулсан уу?

Налайх хангамжийн төв ОНӨААТҮГ дүүргийн Засаг даргын захирамжаар, бусад ОНӨААТҮГ-үүд байгууллагын даргын тушаалаар хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгчдийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулж, тус бүр 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилжээ.

Үнэлгээний хороонд тухайн байгууллагаас ихэвчлэн менежер, аж ахуйн дарга, хүний нөөц, нягтлан бодогч, бичиг хэргийн ажилтныг томилсон ба зөвхөн Асгат ОНӨААТҮГ үнэлгээний хорооны бүрэлдэхүүндээ салбарын мэргэжилтэн буюу эрүүл ахуйч оролцуулсан байна.

Үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүдийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын болон “Худалдан авах ажиллагааны хөтөч”, эдийн засгийн судалгааны “Тактижент”, “Сэтгэл зүйн судалгаа мэдээллийн төв” төрийн бус байгууллага, иргэний төлөөллийг оролцуулан бүрдүүлжээ.

Сангийн сайдын 2021 оны 103 дугаар тушаалаар батлагдсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах, түүний бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 2.3<sup>7</sup>-т заасан салбарын мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулахад анхаарах шаардлагатай байна.

Багачууд хүнс ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сард томилогдсон үнэлгээний хорооны гишүүд нь “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 2.19<sup>8</sup>-д заасан ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлэх мэдэгдлийг гаргаагүй, архивын баримтад хавсаргаагүй байна.

Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хичээлийн жилийн болон төсвийн жилийн эхэнд хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх хугацаатай зэрэгцүүлэн байгуулж худалдан авах ажиллагааг эхлүүлж байгаа нь тодорхой хэмжээнд хугацаа алдахад хүргэж гүйцэтгэгч шалгарах хүртэлх хугацаанд өмнөх бэлтгэн нийлүүлэгчээс худалдан авч байна.

### Үнэлгээний хороо байгуулсан хугацаа

Д/д	Хүнс хангамжийн материал нийлүүлэгч ОНӨААТҮГ	Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх хугацаа	Үнэлгээний хороо байгуулсан огноо	Зарлаж эхлүүлсэн огноо	Тендер зарласан тоо
1	Налайх хангамж төв	2021.09-2022.06	2021.09.27	2021.09.28	2
2	Багачууд хүнс	2022.01-2022.12	2021.12.15	2022.01.22	3
3	Асгат	2022.01-2022.12	2021.12.23	2022.01.26	2
4	Өсвөр үе хүнс	2022.01-2022.12	2022.01.03	2022.01.26	4
5	Хүнс хангамж төв	2022.01-2022.12	2022.01.17	2022.01.21	6

<sup>7</sup> 2.3. “Үнэлгээний хороонд хоёроос доошгүй хөндлөнгийн гишүүн томилох ба нэн тэргүүнд салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын төлөөлөгчийг сонгоно”

<sup>8</sup> 2.19. “Үнэлгээний хороонд томилогдсон гишүүн бүр .. “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийн загварын дагуу тухайн худалдан авах ажиллагаанд оролцоход ашиг сонирхлын зөрчилтэй эсэхээ мэдэгдэнэ”



Тендер зарлах, оролцогчдын материалыг хүлээн авч үнэлэх, сонгон шалгаруулах зэрэгт багадаа нэгээс хоёр сарын хугацаа зарцуулагдаж, эхний сонгон шалгаруулалтаар бүх багцад шаардлагад нийцсэн тендер ирэх магадлал бага байгааг харгалзан үзэж үнэлгээний хороог эртнээс зохион байгуулахад анхаарах шаардлагатай байна.

Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгчдийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог хуулийн дагуу зохион байгуулсан байна.

## 2.2. Тендерийн баримт бичгийг шаардлагын дагуу боловсруулсан уу?

Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгчдийг сонгон шалгаруулах үнэлгээний хороод нь тендерийн баримт бичиг боловсруулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн 19 дүгээр зүйлд заасны дагуу тендерийн баримт бичигт ерөнхий шаардлага болох тендерт оролцогчдод тавих шаардлага, шалгуур үзүүлэлт, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, тендерийн жишиг маягтууд зэргийг тусгажээ.

Багачууд хүнс ОНӨААТҮГ-ын үнэлгээний хороо тендерийн баримт бичигт “гэрээг хэрэгжүүлэх удирдлага, гүйцэтгэх ажилтан, хүнсний технологичтой байх” шалгуур тогтоон “хүний нөөцийн мэдээллийг нотлох баримтын хамт ирүүлнэ” гэж заасан боловч мэргэжлийн диплом, хөдөлмөрийн гэрээ, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээлэл зэргээс аль нотлох баримтыг ирүүлэх талаар тодорхой тусгахгүйгээр орхигдуулсан байна.

Тендерийн баримт бичгийг боловсруулахдаа ОНӨААТҮГ-үүд тендерт оролцогчдод тавих санхүүгийн болон туршлагын шаардлагыг харилцан адилгүй тусгасан нь байна. Тухайлбал:

- Өмнө нь хийж гүйцэтгэж байсан ижил төстэй ажлын гэрээний үнийн дүнгийн шаардлагыг Хүнс хангамж ОНӨААТҮГ батлагдсан төсөвт өртөг болон санал болгох үнийн дүнгийн 100%, Налайх хангамжийн төв, Багачууд хүнс, Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ ӨТҮГ 50%-аас багагүй байхаар тусгасан бол Асгат ОНӨААТҮГ үнийн дүнг тусгайлан шаардаагүй;
- Санхүүгийн чадавхын талаарх шалгуур үзүүлэлтдээ Хүнс хангамж, Налайх хангамжийн төв, Багачууд хүнс ОНӨААТҮГ 2019 он, 2020 оны санхүүгийн тайлангаар ашигтай ажилласан байх шаардлага тавьсан бол Асгат, Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ нь ашигтай ажилласан байх талаар шалгуур тусгаяагүй;
- Малын махны хувьд бүтээгдэхүүнд тавигдах ерөнхий болон эрүүл ахуйн стандарт, зориулалтын тээврийн хэрэгсэлтэй байх шаардлагыг нийтлэг байдлаар тавьсан, Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ нь тендерийн баримт бичигтээ нэмэлтээр хонины махны гулууз 24 кг, үхрийн мах 150 кг-аас багагүй жинтэй байхаар тусгайлан тусгаж өгсөн нь давуу талтай байна.

## 2.3. Худалдан авах ажиллагааны босго үнийг баримталж, зохион байгуулах аргыг хуулийн дагуу сонгосон уу?

Хүнс, хангамжийн материал нийлүүлдэг ОНӨААТҮГ-үүд 2021-2022 онд 23,633.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 82 багц бүхий худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулж 15,316.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21 багцын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, зарласан төсөвт өртөгтэй харьцуулахад 1,190.2 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны хэмнэлт үүсжээ.

*Зохион байгуулсан худалдан авах ажиллагаа*

/сая төг/

№	ОНӨААТҮГ-ын нэр	НТШ-аар зарласан		НТШ-аар шалгарсан		Харьцуулсан хувь	
		Багц	Төсөвт өртөг	Багц	Төсөвт өртөг	Багц	Төсөвт өртөг
1	Өсвөр үе хүнс	19	6,674.7	5	4,559.7	26%	68%



<b>2</b>	Хүнс хангамж	22	6,621.1	6	4,489.7	27%	68%
<b>3</b>	Багачууд хүнс	19	6,331.2	7	5,057.6	37%	80%
<b>4</b>	Асгат	14	2,202.2	1	188.1	7%	9%
<b>5</b>	Налайх хүнс хангамж	8	1,804.2	2	1,021.5	25%	57%
<b>Нийт</b>		<b>82</b>	<b>23,633.3</b>	<b>21</b>	<b>15,316.6</b>	<b>25.6%</b>	<b>64.8%</b>

Тендер шалгаруулалт зарласан багцуудаас голдуу хонь, үхрийн мах, ногоо, сүү, ургамлын тосны багцад гүйцэтгэгчдийг нээлттэй тендерээр сонгон шалгаруулсан нь зарласан багцын тоотой харьцуулахад 25.6%-тай харьцангуй бага байгаа бөгөөд томоохон үнийн дүнтэй багцууд тул батлагдсан нийт төсөвт өртгийн 64.8%-ийг эзэлж байна.

Багачууд хүнс ОНӨААТҮГ хамгийн их буюу зарласан багцын 37%, төсөвт өртгийн 80%-д, харин Асгат ОНӨААТҮГ хамгийн бага буюу багцын 7%, төсөвт өртгийн 9%-д ногдох худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар сонгон шалгаруулж гүйцэтгүүлжээ.

Нээлттэй тендер шалгаруулалтын журмаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан 21 багцын худалдан авах ажиллагааны үр дүнд гэрээний үнийн дүнг зарласан төсөвт өртөгтэй харьцуулахад 1,190.2 сая төгрөгийн хэмнэлт үүсэхээр байна.

#### Худалдан авах ажиллагааны хэмнэлт

/сая.төг/

№	ОНӨААТҮГ	НТШ шалгарсан			
		Багц	Төсөвт өртөг	Гэрээний дүн	ХАА-ны хэмнэлт
<b>1</b>	Багачууд хүнс	7	5,057.6	4,586.7	470.8
<b>2</b>	Хүнс хангамж	6	4,489.7	4,098.8	390.9
<b>3</b>	Өсвөр үе хүнс	5	4,559.7	4,236.4	323.3
<b>4</b>	Асгат	1	188.1	183.5	4.6
<b>5</b>	Налайх хүнс хангамж	2	1,021.5	1,021.0	0.6
<b>Нийт</b>		<b>21</b>	<b>15,316.6</b>	<b>14,126.3</b>	<b>1,190.2</b>

Хүнс хангамж ОНӨААТҮГ-аас бусад 4 газрын үнэлгээний хороод тендер сонгон шалгаруулалт амжилтгүй болсон тохиолдолд шалтгааныг судлах, тендерийн баримт бичгийн агуулгад өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг хэлэлцэх, өөрчлөлт оруулж дахин зарлах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүйгээр 5,828.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 44 багцын худалдан авах ажиллагааг шууд гэрээ байгуулах аргаар зохион байгуулахаар шийдвэрлэн ТБОНӨХБАҮХАТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.4.1<sup>9</sup>, 30.4.3<sup>10</sup> дахь заалтыг зөрчжээ. Үүнд:

- Багачууд хүнс ОНӨААТҮГ 1,273.7 сая төгрөгийн 12 багцад;
- Асгат ОНӨААТҮГ 2,014.1 сая төгрөгийн 13 багцад;
- Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ 1,758.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 багц,
- Налайх хангамжийн төв ОНӨААТҮГ 782.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 багцын гүйцэтгэгчийг гэрээ шууд байгуулах аргаар сонгон шалгаруулахаар шийдвэрлэжээ.

Түүнчлэн эдгээр багцуудад гэрээ шууд байгуулах аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хуульд заасан ерөнхий нөхцөл, санхүүгийн болон техникийн чадавх, туршлага зэрэг шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлсон, хэлэлцсэн, үнэлсэн болон хэлэлцээр хийснийг нотлох баримтгүйгээр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34.2<sup>11</sup> дахь заалтыг зөрчсөн байна.

<sup>9</sup> 30.4.1. “Тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах”;

<sup>10</sup> 30.4.3. “Энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах”

<sup>11</sup> 34.2. “Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхтай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана”



Энэ нь худалдан авах ажиллагааг зохион байгуулсан ажилтнууд ТБОНӨХБАҮХАТХ-ийн 31.1.3-д заасан тендер шалгаруулалтын онцгой журмаар гэрээ шууд байгуулах арга нь уг хуулийн 8.1.2-т заасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахгүйгээр шууд худалдан авалт хийхээс ялгаатай талаар, мөн тэдгээр аргын ялгаа, хэрэглэх нөхцөл, тавигдах шаардлагын талаарх хуулийн мэдлэг хангалтгүйтэй холбоотой байна.

#### 2.4. Шаардлага хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан уу?

Хүнс, хангамжийн материал нийлүүлдэг ОНӨААТҮГ-үүд нээлттэй тендерээр шалгаруулсан 15,316.6 сая төгрөгийн 21 багцын тендерт шалgarsan оролцогчдын ирүүлсэн материалыг тендерийн баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулан хянахад 2 үнэлгээний хороо 4,660.1 сая төгрөгийн 7 багцад тендерийн ерөнхий нөхцөл, санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын шаардлага хангагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан зөрчил илэрлээ. Үүнд:

- Налайх дүүргийн Засаг даргын захирамжаар томилогдсон үнэлгээний хороо нь Налайх Хангамжийн төв ОНӨААТҮГ-ын худалдан авах 170.4 сая төгрөгийн нэг багцын тендерт оролцогч нь тендерийн ерөнхий нөхцөл, техникийн чадавхтай холбоотой 3 төрлийн шалгуур үзүүлэлтийг;
- Хүнс хангамж ОНӨААТҮГ-ын үнэлгээний хороо 4,489.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 багцын тендерт оролцогч 4 аж ахуйн нэгж санхүүгийн болон техникийн чадавх, туршлагатай холбоотой 2-3 төрлийн шалгуур үзүүлэлтийг хангагүй оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулжээ.

Эдгээр нь тендерийн баримт бичгийн 23.2<sup>12</sup>, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 27.1<sup>13</sup>, 27.3<sup>14</sup> дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Тендерийн баримт бичигт тусгагдсан шаардлагыг хангагүй оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан зөрчлүүдийг байгууллага, зарласан багц бүрээр нь шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулан дэлгэрэнгүйгээр /Хавсралт 1/-д харуулав.

Хүнс, хангамжийн материал нийлүүлдэг ОНӨААТҮГ-үүд тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан, 2-4 удаа зарлаад амжилтгүй болсон тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг судалж шийдвэрлээгүй, санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан этгээдтэй хэлцэл хийх арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүйгээр шууд гэрээ байгуулах зэргээр хууль зөрчжээ.

<sup>12</sup> 23.2. “Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрээр ... ирүүлнэ”

<sup>13</sup> 27.1. “Тендер нээсний дараа тендер тус бүр нь ... захиалагчийн тогтоосон чадавхын шаардлага, техникийн тодорхойлолт, тендерийн баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлагыг хангасан эсэхийг хянан үзнэ”

<sup>14</sup> 27.3. “Тендер нь энэ хуулийн 27.1-д заасан бүх нөхцөлийг нэгэн зэрэг хангасан бол шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ”



## СУРГУУЛЬ ЦЭЦЭРЛЭГҮҮДЭД НИЙЛҮҮЛЖ БУЙ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЭС ӨНДӨР БАЙГАА ЭСЭХ

**Сургууль цэцэрлэгүүдэд нийлүүлэх хүнсний бүтээгдэхүүний үнэд хязгаарлалт тогтоосон уу?**

Налайх дүүргийн ИТХ-аас Налайх хангамж төв ОНӨААТҮГ нь бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авсан үнийг хамгийн ихдээ 10%-иар нэмэгдүүлж сургууль, цэцэрлэгүүдэд нийлүүлэхээр тогтоосон, бусад ОНӨААТҮГ-ын хувьд тодорхой хязгаарлалт тогтоосон шийдвэр байхгүй байна.

ОНӨААТҮГ-үүд нь НӨАУГ-аас баталсан орлого, зарлагын зорилтот түвшин, бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгааг харгалзан, сургууль, цэцэрлэгүүдэд нийлүүлэх хүнсний бүтээгдэхүүний үнийг өөрсдөө тогтоодог байна. Энэ үйл ажиллагааг зохицуулах нэгдсэн эрх зүйн бичиг баримт байхгүй байна.

2022 оны эхний хагас жилийн байдлаар 4 газрын бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгжээс худалдан авсан хүнсний бүтээгдэхүүний нийт үнийн дүн дээр НӨАТ ногдуулах болон чөлөөлөх бүтээгдэхүүнээс хамаарч тухайн төрлийн татварт нийт үнийн дүнгээрээ 7.8%, үйл ажиллагааны зардалд 14.0%-ийг шингээн нийтдээ 21.8%-аар нэмэгдүүлж сургууль, цэцэрлэгүүдэд борлуулжээ. Байгууллага бүрээр хүснэгтэд харуулав.

*Худалдан авсан болон борлуулсан бүтээгдэхүүний үнийг харьцуулсан судалгаа*

(сая. төгр)

№	ОНӨААТҮГ	Бэлтгэн нийлүүлэгчээс худалдан авсан нийт үнэ	Сургууль, цэцэрлэгт борлуулсан нийт үнэ	Нэмэгдүүлсэн хувь
1	Асгат	1,341.1	1,708.7	27.4%
2	Хүнс хангамж	2,335.0	2,861.6	22.6%
3	Өсвөр үе хүнс	3,727.8	4,539.2	21.8%
4	Багачууд хүнс	1,941.7	2,271.7	17.0%
<b>Нийт</b>		<b>9,345.5</b>	<b>11,381.2</b>	<b>21.8%</b>

Хамгийн бага буюу Налайх хангамж төв ОНӨААТҮГ тогтоосон хязгаарын хүрээнд 10%, Багачууд хүнс ОНӨААТҮГ 17%-аар нэмэгдүүлж байгаа бол Асгат ОНӨААТҮГ хамгийн их буюу 27.4%-аар нэмэгдүүлэн харилцан адилгүй тогтоож байгаа нь жилийн батлагдсан орлого, зарлага, ашгийн төлөвлөгөө, нийлүүлэх сургууль, цэцэрлэгийн болон бүтээгдэхүүний тоо хэмжээ, нийт үнийн дүн зэргээс хамаарч нэгжид ногдох зардал, нэмэгдүүлэх үнэ харилцан адилгүй байгаатай холбоотой байна.

Бараа бүтээгдэхүүнийг ерөнхий нэр төрлөөр нь ангилж нийт дүнгээр харьцуулбал хүнсний ногооны үнийг хамгийн их буюу 36.4%, малын мах, гурилыг 22.2%, гоймон, нарийн ногоог 19.4%, бусад төрлийн бүтээгдэхүүнийг 15.3-17.9%-ийн нэмэгдэлтэйгээр борлуулсан байна.

*Худалдан авсан үнэ дээр нэмж борлуулсан нэмэгдлийн хувь*

/сая төгр/

№	Бүтээгдэхүүн	Бэлтгэн нийлүүлэгчээс худалдан авсан нийт үнэ	Сургууль, цэцэрлэгт борлуулсан нийт үнэ	Нэмэгдүүлсэн хувь
1	Хүнсний ногоо	896.4	1,222.9	36.4%
2	Малын мах	4,539.8	5,551.9	22.3%
3	Гурил	282.0	344.5	22.2%
4	Нарийн ногоо	178.8	213.7	19.5%
5	Гоймон	195.4	233.1	19.3%
6	Будаа	782.9	923.2	17.9%
7	Сүүн бүтээгдэхүүн	277.2	326.7	17.8%
8	Печень	413.8	487.1	17.7%
9	Элсэн чихэр	224.0	262.5	17.2%
10	Жимс	811.1	946.5	16.7%



<b>11</b>	Ургамлын тос	225.8	260.4	15.3%
<b>12</b>	Бусад	518.4	608.7	17.4%
	<b>Нийт</b>	<b>9,345.5</b>	<b>11,381.2</b>	<b>21.8%</b>

Бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгжээс худалдан авсан бараа бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлж сургууль, цэцэрлэгүүдэд нийлүүлэхэд төсөвт төлж буй НӨАТ, тухайн ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, НӨАУГ-аас баталж байгаа ашгийн зорилтот түвшин голлон нөлөөлж байна.

Хүнс, хангамжийн материал нийлүүлдэг ОНӨААТҮГ-уудын хувьд аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статустай тул НӨАТ төлөгчөөр бүртгэгдсэний улмаас уг татвараас чөлөөлөгддөг дотоодод үйлдвэрлэсэн гурил, мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо, байгалийн жимс зэрэг гол бүтээгдэхүүний үнэ дээр 10% шууд нэмэгдэж сургууль, цэцэрлэгүүдэд нийлүүлэх үнийг улам өсгөхөд хүргэж байна.

Тухайлбал хэрэв хүнс, хангамжийн материал нийлүүлдэг ОНӨААТҮГ-уудыг НӨАТ-аас чөлөөлөх, эсвэл уг татварыг төлөгч аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар бус төсвөөс санхүүждэг төсөвт үйлдвэрийн газар гэсэн статусаар өөрчлөн зохион байгуулбал гурил, мах, сүү, хүнсний ногоо зэрэг нийт өртгийн 65%-ийг эзэлдэг гол бүтээгдэхүүнүүдийг НӨАТ-ын 10% хассан үнээр борлуулах, өртгийг хагас жилд 670.0 орчим сая төгрөгөөр бууруулах боломж бүрдэхээр байна.

Нөгөө талаар эдгээр ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагааны зардал, нийлүүлэх үнийг хязгаарлах, тодорхой түвшинд барихад чиглэсэн зохицуулалт хангалтгүй, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статустай, НӨАУГ-аас зорилтот түвшинг батлахдаа ашиг олох, нийслэлийн төсөвт ногдол ашиг төвлөрүүлэх шаардлага тавьж байгаа нь сургууль, цэцэрлэгүүдэд эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг зах зээлийн боломжит үнээр нийлүүлэх үндсэн зорилго, үйл ажиллагааны онцлогт нь нийцэхгүй байна.

Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх орон нутгийн өмчит газар тусгайлан үйл ажиллагаа явуулснаар аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статусаас хамаарсан үйл ажиллагааны болон НӨАТ-ын зардал шингэж сургууль цэцэрлэгүүдэд нийлүүлэх бүтээгдэхүүний үнэ өсөхөд хүргэж байгаа сул талтай ч худалдан авах ажиллагааг нэгтгэн зохион байгуулах, хүнсний бүтээгдэхүүнд эрүүл ахуй, стандартын чиглэлээр хяналт тавихад илүү давуу талтай байна. Тухайлбал:

- Худалдан авах ажиллагааг нэгтгэн зохион байгуулснаар сургууль, цэцэрлэг бүр жижиг байгууллага, иргэнээс бус томоохон нийлүүлэгч аж ахуйн нэгж, үйлдвэрлэгчээс авах, харилцан адилгүй үнээр бус харьцангуй тогтмол, ойролцоо үнээр бүтээгдэхүүн худалдан авах;
- Хүнсний бүтээгдэхүүний өнгө, үнэр, бүрэн бүтэн байдал, хадгалах хугацаа зэргийг эрүүл ахуйч биетээр хянаж махны хувьд мал эмнэлгийн гарал үүслийн гэрчилгээг, мах, ногоо, жимс зэрэг түргэн муудах бүтээгдэхүүнд сар тутам, хуурай хүнсний бүтээгдэхүүнд улирал тутам лабораторийн шинжилгээ хийлгэх шаардлага тавьж, түүний үр дүнд лабораторийн шинжилгээгээр антибиотикийн үлдэгдэл, хордлого үүсгэдэг бичил биет, гэдэсний нянгийн халдвар, нянгийн тоо, хүчиллэг, шүлтлэг байдал, төмөрлөг хольц, нитрат, хөнөөлт өвчин, хачиг, шавж, бактери, хөгц мөөгөнцөр зэрэг үзүүлэлтүүдээр стандартын шаардлага хангасан эсэхэд хяналт тавих;
- Долоо хоног бүр захиалга авч зориулалтын тээврийн хэрэгслээр түгээлт хийх, нийлүүлсэн тоо хэмжээ, дуусах хугацааг сургууль, цэцэрлэг бүрээр бүртгэх, бүтээгдэхүүнтэй холбоотой санал гомдол гарах тохиолдолд хариуцах аж ахуйн нэгжтэй тул шалтгааныг тодруулах, буцаалт хийх, солих боломжтой зэрэг давуу талтай байна.





Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн цэцэрлэгүүд, зарим сургуулиудад хүнс, хангамжийн материал нийлүүлдэг эдгээр газруудыг төрөөс баримталж байгаа бодлогын хүрээнд хүүхдийн хоолны эрүүл ахуй, чанар стандарт талаас нь тодорхой хэмжээгээр стратегийн ач холбогдол бүхий чиглэлд хамруулах тохиолдолд байгууллагын одоогийн статусаас хамаарч буй сул талыг бууруулах, урт хугацаанд тогтмол хийгддэг худалдан ажиллагааг ерөнхий гэрээгээр зохион байгуулах боломжийг судалж шийдвэрлэх шаардлагатай байна.


### **Сургууль цэцэрлэгүүдэд нийлүүлж байгаа хүнсний бүтээгдэхүүний үнэ зах зээлийн үнээс өндөр байна уу?**

Нийслэлийн Статистикийн газар төвийн 6 дүүргийн хэмжээнд зарим зах, хүнс худалдаалагч аж ахуй нэгжүүдэд зарагдаж байгаа хүнсний гол нэрийн цөөхөн хэдэн бүтээгдэхүүний зах зээлийн жижиглэнгийн үнийн судалгаа хийж цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж байна.



Тодорхой тогтсон хугацааны цуваа, дараалал бүхий, тогтмол гаргадаг, албан ёсны үнийн судалгаа мэдээлэл өөр байхгүй байгаа тул Нийслэлийн Статистикийн газрын цахим хуудас дахь 7 хоногийн үнийн танилцуулгаас 11 бүтээгдэхүүний жижиглэнгийн дундаж үнийг зах зээлийн үнээр төлөөлүүлэн хүнс, хангамжийн материал нийлүүлдэг ОНӨААТҮГ-уудын сургууль, цэцэрлэгт 2022 оны эхний хагас жилд нийлүүлсэн үнэтэй харьцуулан графикаар харуулав. Үүнд:

- Сургууль, цэцэрлэгүүдэд нийлүүлэх бүтээгдэхүүний үнийн дунд хамгийн их хувийн жин эзэлдэг үхрийн мах, хонины мах, цагаан будааг статистикийн мэдээлэл дахь зах зээлийн жижиглэнгийн үнэтэй харьцуулахад харьцангуй бага үнээр нийлүүлсэн.





- Ургамлын тос, элсэн чихрийг статистикийн мэдээлэл дахь бүтээгдэхүүний үнэтэй харьцуулахад дээгүүр үнээр борлуулсан.



Хүнс, хангамжийн материал нийлүүлдэг ОНӨААТҮГ-үүд зах зээлийн жижиглэнгийн үнээс хонины мах, үхрийн мах, цагаан будаа, төмс, лууван, байцаа, хүрэн манжин, сонгино зэрэг 8 төрлийн бүтээгдэхүүнийг бага үнээр, гурил, ургамлын тос, элсэн чихэр зэрэг 3 бүтээгдэхүүнийг зах зээлийн жижиглэнгийн үнээс өндөр үнээр сургууль, цэцэрлэгүүдэд борлуулсан байна.



## АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад олж цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Хүнс, хангамжийн материал нийлүүлдэг ОНӨААТҮГ-ууд шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллийн 97.8%-ийг мэдээлж, үүнээс 98.9%-ийг хугацаанд нь байршуулан шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллажээ.
2. Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг цахим системээр зохион байгуулан батлагдсан нийт төсөвт өртгийн 64.8%-тай тэнцэх багцуудад гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар сонгожээ.
3. Тендерийн баримт бичигт тусгасан шалгуур үзүүлэлтийг хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан, 2-4 удаа зарлаад амжилтгүй болсон тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг судалж шийдвэрлээгүй, санхүү, техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан этгээдтэй хэлцэл хийх арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүйгээр шууд гэрээ байгуулах зэргээр хууль зөрчжээ.
4. Налайх хангамж төв ОНӨААТҮГ-аас бусад ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагааны зардал, нийлүүлэх үнийг хязгаарлах, тодорхой түвшинд барихад чиглэсэн зохицуулалт хангалтгүй, бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгжээс худалдан авсан хүнсний бүтээгдэхүүний үнэ дээр НӨАТ ногдуулах болон чөлөөлөх бүтээгдэхүүнээс хамаарч тухайн төрлийн татварт нийт үнийн дүнгээрээ 7.8%, үйл ажиллагааны зардалд 14.0%-ийг шингээн нийтдээ 21.8%-аар нэмэгдүүлж сургууль, цэцэрлэгүүдэд борлуулжээ.
5. Тухайн байгууллагуудыг НӨАТ-аас чөлөөлөх, эсвэл татвар төлөгч аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар бус төсвөөс санхүүждэг төсөвт үйлдвэрийн газар гэсэн статусаар өөрчлөн зохион байгуулбал сургууль, цэцэрлэгүүдэд нийлүүлэх үнийг бууруулах боломж бүрдэхээр байна.
6. Сургууль, цэцэрлэгүүдэд эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг зах зээлийн боломжит үнээр нийлүүлэх үндсэн зорилготой ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагааны зардал, нийлүүлэх үнийг хязгаарлах, тодорхой түвшинд барихад чиглэсэн зохицуулалт хангалтгүй, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статустай, НӨАУГ-аас зорилтот түвшнийг батлахдаа ашиг олох, нийслэлийн төсөвт ногдол ашиг төвлөрүүлэх шаардлага тавьж байгаа нь зорилго, үйл ажиллагааны онцлогт нь нийцэхгүй байна.



## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.  
Үүнд:

**Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд:**

- Хүнс, хангамжийн материал нийлүүлдэг ОНӨААТҮГ-ууд нь НӨАТ төлөгчөөр бүртгэгдсэний улмаас гол нэрийн бүтээгдэхүүний үнэ дээр 10% шууд нэмэгдэж үнийн өсөлтөд нөлөөлж байгааг судалж, уг татвараас чөлөөлүүлэх, эсвэл НӨАТ төлөгч аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар бус төсвөөс санхүүждэг төсөвт үйлдвэрийн газар гэсэн статусаар өөрчлөн зохион байгуулах боломж, эрх зүйн зохицуулалтыг судалж шийдвэрлэх;
- Тухайн байгууллагуудыг нэгтгэн удирдлага зохион байгуулалтыг өөрчлөх, захиргааны зардлыг багасгах замаар сургууль цэцэрлэгт нийлүүлэх бүтээгдэхүүний нэгж үнийг бууруулах боломжтой эсэхийг судалж шийдвэрлэх;
- Төрөөс баримталж байгаа бодлогын хүрээнд хүүхдийн хоолны эрүүл ахуй, чанар стандарт талаас нь тодорхой хэмжээгээр стратегийн ач холбогдол бүхий чиглэлд хамруулж байгууллагын одоогийн статусаас хамаарч буй сул талыг бууруулах, урт хугацаанд тогтмол хийгддэг худалдан авах ажиллагааг ерөнхий гэрээгээр зохион байгуулах боломжийг судалж шийдвэрлэх.

**Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газарт:**

- Сургууль, цэцэрлэгүүдэд эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг зах зээлийн боломжит үнээр нийлүүлэх зорилготой газруудын зорилтот түвшнийг батлахдаа ашиг олох, нийслэлийн төсөвт ногдол ашиг төвлөрүүлэх шаардлага тавьж байгаа нь үндсэн зорилго, үйл ажиллагааны онцлогт нь нийцэхгүй байгааг судалж холбогдох газарт статусын асуудлыг тавьж шийдвэрлүүлэх.
- Борлуулах бүтээгдэхүүний үнийн хязгаарлалтыг орлого, зарлагын зорилтот түвшнээр дамжуулан тогтоох.

**Хүнс, хангамжийн материал нийлүүлдэг ОНӨААТҮГ-уудын дарга нарт:**

- Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгчийг сонгох нээлттэй тендер шалгаруулалт амжилтгүй болсон тохиолдолд тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг судалж шийдвэрлэх, зөвхөн хуульд заасан санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан этгээдтэй шууд гэрээ байгуулах хэлцэл хийж баримтжуулж хэвших.
- Тендер зарлах, оролцогчдын материалыг хүлээн авч үнэлэх, сонгон шалгаруулах зэрэгт багадаа нэгээс хоёр сарын хугацаа зарцуулагдаж, эхний сонгон шалгаруулалтаар бүх багцад шаардлагад нийцсэн тендер ирэх магадлал бага байгааг харгалзан үзэж үнэлгээний хороог байгуулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажиллагааг эртнээс эхлүүлэх.



## ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДААС ИРҮҮЛСЭН САНАЛ



### НИЙСЛЭЛИЙН АСГАТ ОНӨААТУГ

Жалжанхүйтэгт Дамдинбазарын гудамж,  
18 дугаар хороо, Багногол дүүрэг Улаанбаатар хот, 16067  
Утас: (976) 7712 4477, 7712 4466  
Цахим шурдан: info@asgat.ub.gov.mn  
Цахим хуудас: www.asgat.gov.mn

2022.11.29 № 108  
танай 2022.11.29 -ны № 1091 -т

#### ГНИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Манай байгууллага аудитын тайланийн төсөлтэй санал нэг байна. Мөн аудитаас өгсөн зөвлөмжийг цаашид хэрэгкүүлж ажиллах болно.

Асгат ОНӨААТУГ  
Удирдлага  
Захирал  
Энхбат Энхтөр  
2022.11.29 15:03



### НИЙСЛЭЛИЙН ӨСВЕР ҮЕ ХҮНС ОНӨААТУГ

Да хүрээ гудамж, 19 дүгээр хороо,  
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13290  
Утас: (976-11) 45 69 22, факс: (976-11) 45 89 63  
Цахим шурдан: info@childhood.ub.gov.mn  
Цахим хуудас: childhood.ub.gov.mn

2022.11.29 № 176  
танай 2022.11.29 -ны № 1091 -т

#### ГНИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Танай газраас ирүүлсэн Нийслэлийн Аудитын тайланийн төсөлтэй танилцлаа.

Хүргүүлэх санал байхгүй болно.

Өсвер Үе Хүнс ОНӨААТУГ  
Захиргаа  
Захирал  
Ганбаттар Мэнхзүл  
2022.11.29 17:02



### НИЙСЛЭЛИЙН БАГАЧУУД ХҮНС ОНӨААТУГ

Сургуулийн гудамж 24, 13 дугаар хороо  
Чингэлэй дүүрэг, Улаанбаатар хот, 15110  
Утас: (976-11) 35 78 13  
Цахим хуудас: www.bagachuuukhuns.ub.gov.mn

дэдэл. 11.29 № 149.  
таний дэдэл 11.29 -ны № 1091. -т

ГНИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Танай байгууллагаас ирүүлсэн нийцлийн аудитын тайлантай танилцлаа. Ямар нэгэн саналгүй байна.



ЗАХИРАЛ   
Б.МӨНХНАСАН

### НИЙСЛЭЛИЙН НАЛАЙХ ДҮҮРГИЙН НАЛАЙХ ХАНГАМЖИЙН ТӨВ ОНӨААТУГ

Д.Даваажавын гудамж, 2 дугаар хороо,  
Налайх дүүрэг, Улаанбаатар хот, 12790  
Утас: (976-11) 7023 3633  
Цахим шурдан: nalakh.tov@gmail.com


2022.11.29 № 19  
танай -ны № -т

#### ГНИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу аудитын тайланийн төсөлтэй танилцсан.

Тайланийн төсөлд зэрчмийн зөрүү, саналгүй болно.

ЗАХИРАЛ   
О.ЭНХТАЙВАН



### ГНИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Хүнс Хангамж Төв ОНӨААТУГ  
Нарангийн гудамж, 2 дугаар хороо  
Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот, 18101  
Утас: (976) 7766 0360  
Цахим хуудас: info@sc.ub.gov.mn

2022.11.29 № 197  
танай 2022.11.29 -ны № 1091 -т

ГНИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Тус газраас ирүүлсэн аудитын тайлантай танилцлаа.

2.4. Шаардлагын хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан эсэх гэсэн

заалтад хавсралтаар тайлбар хүргүүлэв.

Аудитын шалгалтын арга зүй зөвлөмжийн дагуу Худалдан авах ажиллагааг зохион байгуулахад төнөрний баримт бичгийн шаардлагыг илүү дэлгэрнүүг тайлбарлаж бичих, утга найруулгад цаашид анхаарч ажиллах болно.

Хавсралт 4 хуудастай.

Хүнс Хангамж Төв ОНӨААТУГ  
Удирдлага  
Захирал  
Даваадорж Идрэзала  
2022.11.29 19:26



НИЙСЛЭЛИЙН СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГҮҮДЭД ХҮНС, ХАНГАМЖИЙН МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛДЭГ ОНӨААТУГ-УУДЫН ШИЛЭН  
ДАНС, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

Хүнс хангамж ОНӨААТУГ

2022 оны Сонгинохайрхан дүүргин цэцэрлэгүүдийн хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер

ТББ-т заасан шалгур үзүүлэлт		Шалгур үзүүлэлтийг хангагуу талаарх тайлбар
18.6.4.	Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл Шаардлагатай: Бүх багцын хувьд сүүлийн 2 жил /2020 он, 2021 он/-ийн хугацаанд санал болгож буй уүний дүнгээс багагүй дүнтэй барааны нийлүүлэгчээр ядаж 1 удаа ажилласан туршлагатай байх шаардлагатай. Г/эрээ, гэрээ дүгнэсэн акт, мөн гэрээтэй байгууллагын тодорхойлолт ирүүлнэ/	Тендерт оролцогч нь Гэрээ, гэрээ дүгнэсэн акт ирүүлсэн бөгөөд гэрээ дүгнэсэн актанд тус байгууллагын гэрээний биелэлт, дүгнэлт хангалттай гэж ирүүлсэн нь тухайн байгууллагын тодорхойлолт ирүүлсэн гэж үзж байна
24.5.3.8	Мэргэжлийн хяналтын байцаагчийн агуулах, зоорины эрүүл ахуйн орчны талаар гаргасан дүгнэлт /бүх багцад/	Алу дейри ХХК Тендерийн баримт бичгийн 16 дугаар хуудаст Мэргэжлийн хяналтын газар улсын байцаагчийн дүгнэлт Алу ХК-н нэр дээр агуулах ўл ажиллагааны тухай шаардлагыг хангасан тухай дүгнэлт ирүүлсэн нь Өөрийн эзэмшилжийн агуулах зоорины мэдээлэл ирүүлэх гэсэн шаардлагыг хангасан гэж үзж байна. Грийн Имлэх ХХК нь Байгууллагын тендерийн баримт бичгийн дас дугаар 5 дээр Ажиллах хүчиний мэдээлэл хуудас 18-22т Үлд хедлэх эд хөрөнгө эмчлэх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ мөн агуулахын түрээсийн гэрээ ирүүлсэн
18.6	Тендерт оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгур үзүүлэлт, шаардлага: Ижил төстэй гэрээний туршлага: 2020 он 2021 оны аль нэгд, Уг хугацаанд батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгээс багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээ доод тал нь 1 удаа	Тендерийн баримт бичигт 2020 онд Хонь мах дээр Багачууд хүнс ОНӨААТУГ-т 820,125,000 төгрөг. Цэргийн төв эмнэлэгт 111,132,000 төгрөг. Хүнс хангамж төв ОНӨААТУГ-т 962,500,000 төгрөг нийт 1,893,757,000 төгрөгийн гэрээ, гэрээ дүгнэсэн акт ирүүлсэн байна. Тус онд Үхрийн мах нийлүүлэх Багачууд хүнс ОНӨААТУГ/Газарт 1,190,082,500 төгрөг, Цэргийн төв эмнэлэгт 55,248,480 төгрөг, Хүнс хангамж төв ОНӨААТУГ-т 704,230,000 төгрөгийн нийт 1,949,540,980 төгрөгийн гэрээ ирүүлсэн. 2021 онд хониных мах нийлүүлэх гэрээ Багачууд хүнс 435,210,000 төгрөг. Өсвөр үе хүнс ОНӨААТУГ-тai 648,890,000 төгрөг. Хүнс хангамж төв ОНӨААТУГ-тai 580,000,000 төгрөгийн нийт 1,964,100,000 гэрээ дүгнэсэн акт ирүүлсэн. Мөн тус онд үхрийн мах нийлүүлэх Багачууд хүнс ОНӨААТУГ-тai 720,900,000 төгрөг, Өсвөр үе хүнс ОНӨААТУГ-тai 142,588,800 төгрөг. Хүнс хангамж төв ОНӨААТУГ-тai 689,425,000 төгрөг нийт 1,552,913,800 төгрөгийн гэрээ, гэрээ дүгнэсэн акт ирүүлсэн нь уг хугацаанд батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгээс багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээ доод тал нь 1 удаа гэсэн шаардлагыг хангасан гэж үзж байна
18.6.3	Гэрээг хэрэгжүүлэхдээ төлөөлөн оролцох төслийн удирдагч болон мэргэжлийн ажилтын мэдээллийг тусгайлан ирүүлэх шаардлагатай. Үүнд Тендерт оролцогч Нь дор хаяж Багц 1, 2, 3, 4-т - Төслийн удирдагч-1 - Хүнсний технологич, эрүүл ахуйч, мааны эмч аль нэг веерийн ўл ажиллагааны чиглэлийн мэргэжилтэнтэй байх /иргэний үнэмлэх, диплом, НДВ 2021 онц /12 сар/	Тус байгууллагын ажиллах хүчин чадал дээр Нийгмийн эрүүл ахуй гэсэн дипломтой ажилтан ирүүлсэн нь хоол хүнс, эрүүл ахуй мэргэжлийн шалгруут зөвшөөрдөг. Эрүүл ахуйч Баинбилигэг овогтой Жавхлан нь Эрдэнэ Энх трэйд ХХК-тай үйлчилгээ үзүүлэх гэрээтэй бөгөөд гэрээний 6.2т Гүйцэтгэгч тал нь НДШ. ХХОАТ тайллангаа хариучнаа гэж заасан байна. Гэрээг хэрэгжүүлэхдээ төлөөлөн оролцох төслийн удирдагч болон мэргэжлийн ажилтын мэдээллийг тусгайлан ирүүлэх шаардлагыг хангаж байна гэж үзж байна. Эрдэнэ Энх трэйд ХХК нь Б.Жавхлантай хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй хөлсөөр ажиллах гэрээтэй байх тул НДВ маягтад Жавхлангийн НДШ төлсөн мэдээлэл карагдахгүй байгаа болно. Хөлсөөр ажиллах гэрээ нь хуулиар хориглосон зүйлги тул эрүүл ахуйтай гэж үзсэн

II



## ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГӨХ ХАРИУ ТАЙЛБАР

Хүнс хангамж төв ОНӨААТҮГ-ын 2022 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн 197 тоот албан бичгээр аудитын тайлангийн төсөлд дараах 4 саналыг ирүүлснийг хянахад тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт бүрээр үнэлэхгүйгээр нэг шалгуураар нөгөө шалгуур үзүүлэлтийг орлуулан үнэлсэн гэсэн тайлбар ирүүлсэн нь хууль эрхзүйн үндэслэлгүй байх тул хүлээн авах боломжгүй бөгөөд аудитын тайланд засвар өөрчлөлт оруулаагүй болно. Үүнд:

*Ирүүлсэн санал 1. “Тендерт оролцогч нь гэрээ, гэрээ дүгнэсэн акт ирүүлсэн бөгөөд гэрээ дүгнэсэн актад тус байгууллагын гэрээний биелэлт, дүгнэлт хангалттай гэж ирүүлсэн нь тухайн байгууллагын тодорхойлолт ирүүлсэн гэж үзэж байна”*

*Саналд өгөх хариу тайлбар: Тендерийн баримт бичигт гэрээ, гэрээ дүгнэсэн акт, захиалагч байгууллагын тодорхойлолт ирүүлэх гэсэн 3 төрлийн шалгуур үзүүлэлт тусгасан тохиолдолд гэрээ, гэрээ дүгнэсэн актыг ирүүлж, захиалагч байгууллагын тодорхойлолтыг ирүүлээгүй тохиолдолд ТБОНӨХБАҮХАТХ-ийн 27.3<sup>15</sup>, 27.4<sup>16</sup> заасны дагуу бүх нөхцөлийг нэгэн зэрэг хангаагүй байх тул шаардлагад нийцээгүй гэж үзэж тендерээс татгалзах ёстой тул ирүүлсэн саналыг хүлээн авах боломжгүй.*

*Ирүүлсэн санал 2. “Тендерийн баримт бичгийн 16 дугаар хуудаст Мэргэжлийн хяналтын газар улсын байцаагчийн дүгнэлт АГУ ХК-н нэр дээр агуулах үйл ажиллагааны тухай шаардлагыг хангасан тухай дүгнэлт ирүүлсэн нь өөрийн эзэмшилийн агуулах зоорини мэдээлэл ирүүлэх гэсэн шаардлагыг хангасан гэж үзэж байна”*

*Саналд өгөх хариу тайлбар: Тендерийн баримт бичигт агуулахын үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар, Мэргэжлийн хяналтын байцаагчийн агуулах, зоорини эрүүл ахуйн орчны талаар гаргасан дүгнэлт ирүүлэх гэсэн 2 төрлийн шалгуур үзүүлэлт тусгасан тохиолдолд Мэргэжлийн хяналтын байцаагчийн дүгнэлтийг ирүүлж, агуулахын үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбарыг ирүүлээгүй тохиолдолд хуульд заасны дагуу бүх нөхцөлийг нэгэн зэрэг хангаагүй байх тул шаардлагад нийцээгүй гэж үзэж тендерээс татгалзах ёстой тул ирүүлсэн саналыг хүлээн авах боломжгүй.*

*Ирүүлсэн санал 3. “2020 онд 3 байгууллагад нийт 1,893.8 сая, 2021 онд 3 байгууллагад нийт 1,964.1 сая төгрөгийн хонины мах, 2020 онд 3 байгууллагад нийт 1,949.5 сая, 2021 онд 3 байгууллагад нийт 1,552.9 сая төгрөгийн үхрийн мах нийлүүлсэн гэрээ, гэрээ дүгнэсэн акт ирүүлсэн нь уг хугацаанд батлагдсан төсөөт өртгийн үнийн дүнгээс багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээ доод тал нь 1 удаа гэсэн шаардлагыг хангасан гэж үзэж байна”*

*Саналд өгөх хариу тайлбар: Тендерийн баримт бичигт “... батлагдсан төсөөт өртгөөс болон санал болгож буй үнийн дүнгээс багагүй үнийн дүнтэй барааны нийлүүлэгчээр ядаж 1 удаа ажилласан туршлагатай байх шаардлагатай” гэж тусгасан боловч оролцогчийн ирүүлсэн тендерийн материалыг үнэлэхдээ 3 байгууллагатай хийсэн бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний нийт үнийн дүнгээр тооцож*

<sup>15</sup> 27.3. “Тендер нь энэ хуулийн 27.1-д заасан бүх нөхцөлийг нэгэн зэрэг хангасан бол шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ”

<sup>16</sup> 27.4. “Энэ хуулийн 27.3-т зааснаас бусад тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзэж захиалагч уг тендерээс татгалзана”



шалгуур хангасан гэж үзсэн нь үндэслэлгүй байх тул ирүүлсэн саналыг хүлээн авах боломжгүй.

*Ирүүлсэн санал 4. “... Нийгмийн эрүүл ахуй гэсэн дипломтой ажилтан ирүүлсэн нь хоол хүнс, эрүүл ахуйч мэргэжлийн шалгуурт зөвшөөрдөг. Эрүүл ахуйч нь ... үйлчилгээ үзүүлэх гэрээтэй, гэрээний 6.2-т гүйцэтгэгч тал нь нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын тайлангаа хариуцна гэж заасан, ... мэргэжлийн ажилтны мэдээллийг тусгайлан ирүүлэх шаардлагыг хангаж байна гэж үзэж байна. Тендерийн баримт бичигт үндсэн ажилтан байх гэж шаардаагүй ...”*

*Саналд өгөх хариу тайлбар: Тендерийн баримт бичигт “гэрээг хэрэгжүүлэхэд оролцох мэргэжлийн ажилтны мэдээллийг тусгайлан ирүүлэх шаардлагатай, ... хүнсний технологич, эрүүл ахуйч, малын эмч аль нэг өөрийн үйл ажиллагааны чиглэлийн мэргэжилтэнтэй байх, диплом, 2021 оны 12 дугаар сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн НД-8 маягт ирүүлэх”-ээр заасан.*

Гэтэл тендерийн баримт бичигт шаардсанас өөр буюу “*нийгмийн эрүүл мэнд судлаач*” гэсэн мэргэжлийн диплом ирүүлсэн, хууль журам зааварт тухайн мэргэжлийг адилтгах талаар холбогдох нотлох баримтыг ирүүлээгүй, мөн тендерийн баримт бичигт шаардсан 2021 оны 12 дугаар сарын НД-8 маягтад тухайн иргэний нэр дээр нийгмийн даатгалын шимтгэл төлөгдөөгүй байгаа тул ирүүлсэн саналыг хүлээн авах боломжгүй байна.



Хавсралт 1

Тендерийн баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтийг хангаагүй  
гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан зөрчлүүд

(сая. төг)

№	Багцын нэр	Гүйцэтгэгчийн нэр	Төсөвт өртөг	ТББ-т заасан шалгуур үзүүлэлт	Зөрчлийн утга
---	------------	-------------------	--------------	-------------------------------	---------------

Хүнс хангамж ОНӨААТҮГ

1	Багц 21. Ургамлын тос	Грийн импекс ХХК	80.3	24.5	Мэргэжлийн хяналтын байцаагчийн агуулах, зоорины эрүүл ахуйн орчны талаар гаргасан дүнгэлт /бүх багцад/	Мэргэжлийн хяналтын байцаагчийн агуулах, зоорины эрүүл ахуйн орчны талаар гаргасан дүнгэлтийг ирүүлээгүй.
				18.6 .4.	Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл: Шаардлагатай: Бүх багцын хувьд сүүлийн 2 жил /2019 он, 2020 он/-ийн хугацаанд санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй дүнтэй барааны нийлүүлэгчээр ядаж 1 удаа ажилласан туршлагатай байх шаардлагатай. /Гэрээ, гэрээ дүгнэсэн дүгнэсэн акт, мөн гэрээтэй байгууллагын тодорхойлолт ирүүлнэ/	2019 он, 2020 оны ижил төстэй ажлын мэдээлэл шаардсан байхад 2020, 2021 оны мэдээлэл ирүүлсэн, 2019 оны мэдээлэл ирүүлээгүй, ижил төстэй бараа нийлүүлсэн баримтад зөвхөн гэрээг ирүүлсэн, гэрээ дүгнэсэн акт, гэрээтэй байгууллагын тодорхойлолтыг ирүүлээгүй.
2, 3	Багц 1. Хонинь Мах Багц 2. Үхрийн Мах дайвар бүтээгдэхүүн	Хулагуу холдинг ХХК	3,483.3	18.6 .4.	Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл: Шаардлагатай: Бүх багцын хувьд сүүлийн 2 жил /2020 он, 2021 он/-ийн хугацаанд санал болгож буй үнийн дүнгээс багагүй дүнтэй барааны нийлүүлэгчээр ядаж 1 удаа ажилласан туршлагатай байх шаардлагатай. /Гэрээ, гэрээ дүгнэсэн акт, мөн гэрээтэй байгууллагын тодорхойлолт ирүүлнэ/	Санал болгож буй үнийн дүнгээс (хонинь мах багцын 1,630.2 сая, үхрийн мах дайвар бүтээгдэхүүний багцын 1,493.2 сая) багагүй дүнтэй барааны нийлүүлэгчээр ядаж 1 удаа ажилласан туршлагатай байх шаардлага хангаагүй, мөн гэрээтэй байгууллагын тодорхойлолтыг ирүүлээгүй.
				18.6 .	Тендерт оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгур үзүүлэлт, шаардлага: Ижил төстэй гэрээний туршлага: 2020 он 2021 оны аль нэгд, Уг хугацаанд батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгээс багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээ доод тал нь 1 удаа	Хонинь мах багцын 1,852.5 сая, үхрийн мах дайвар бүтээгдэхүүний багцын 1,630.8 сая төгрөгийн төсөвт өртгийн үнийн дүнгээс багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээ доод тал нь 1 удаа гэсэн шалгуур хангаагүй.
4, 5	Багц 14. Сүүний багц Баруун бүс Багц 15. Сүүний багц Зүүн бүс	Агуу дэйри ХХК	615.6	24.5 .3.8	Өөрийн эзэмшилийн агуулах зоорины мэдээлэл ирүүлэх /ул хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар, түрээсийн бол түрээсийн гэрээ, Мэргэжлийн хяналтын байцаагчийн агуулах, зоорины эрүүл ахуйн орчны талаар гаргасан дүнгэлт	Өөрийн эзэмшилийн агуулах зоорины мэдээлэл болох үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбарыг ирүүлээгүй.
				18.6 .4.	Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл: Шаардлагатай: Бүх багцын хувьд сүүлийн 2 жил /2020 он, 2021 он/-ийн хугацаанд санал болгож буй үнийн дүнгээс багагүй дүнтэй барааны нийлүүлэгчээр ядаж 1 удаа ажилласан туршлагатай байх шаардлагатай. /Гэрээ, гэрээ дүгнэсэн акт, мөн гэрээтэй байгууллагын тодорхойлолт ирүүлнэ/	Зөвхөн 2020 онд 28.9 сая төгрөгийн сүүн бүтээгдэхүүн нийлүүлсэн гэрээ, гэрээ дүгнэсэн актагдаж ирүүлсэн, гэрээтэй байгууллагын тодорхойлолт ирүүлээгүй, шалгуурт заасан санал болгож буй үнийн дүнгээс багагүй барааны нийлүүлэгчээр ажилласан байх шаардлага хангаагүй.



НИЙСЛЭЛИЙН СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГҮҮДЭД ХҮНС, ХАНГАМЖИЙН МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛДЭГ ОНӨААТҮГ-УУДЫН ШИЛЭН  
ДАНС, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

				18.6 .	Тендерт оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгур үзүүлэлт, шаардлага: Ижил төстэй гэрээний туршлага: 2020 он 2021 оны аль нэгд, Уг хугацаанд батлагдсан төсөвт өртигийн үнийн дүнгээс багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээ доод тал нь 1 удаа	Зөвхөн 2020 онд 28.9 сая төгрөгийн сүүн бүтээгдэхүүн нийлүүлсэн гэрээ, гэрээ дүгнэсэн актыг зөвхөн ирүүлсэн, шалгуурт заасан санал болгож буй үнийн дүнгээс багагүй барааны нийлүүлэгчээр ажилласан байх шаардлагыг хангаагүй.
6	Багц 3. Хүнсний ногоо	Эрдэнэ энх трейд ХХК	310.6	18.6 .4.	Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл: Шаардлагатай: Бүх багцын хувьд сүүлийн 2 жил /2020 он, 2021 он/-ийн хугацаанд санал болгож буй үнийн дүнгээс багагүй дүнтэй барааны нийлүүлэгчээр ядаж 1 удаа ажилласан туршлагатай байх шаардлагатай. /Гэрээ, гэрээ дүгнэсэн акт, мөн гэрээтэй байгууллагын тодорхойлолт ирүүлнэ/	Ижил төстэй ажлын гэрээ, гэрээ дүгнэсэн актыг зөвхөн ирүүлсэн, гэрээтэй байгууллагын тодорхойлолт ирүүлэх шаардлагыг хангаагүй.
				18.6 .3	Гэрээг хэрэгжүүлэхэд төлөөлөн оролцох төслийн удирдагч болон мэргэжлийн ажилtnы мэдээллийг тусгайлан ирүүлэх шаардлагатай. Үүнд: Тендерт оролцогч нь дор хаяж Багц 1, 2, 3, 4-т - Төслийн удирдагч-1 - Хүнсний технологич, эрүүл ахуйч, малын эмч аль нэг өөрийн үйл ажиллагааны чиглэлийн мэргэжилтэнтэй байх /иргэний үнэмлэх, диплом, НД8 2021 оны 12 сар/	Эрүүл ахуй гэх хүний материал ирүүлсэн ч тендерийн бичиг баримтад зааснаас өөр мэргэжил буюу нийгмийн эрүүл мэнд судлаач гэсэн мэргэжлийн дипломтой, мөн 2021 оны 12 дугаар сарын НД8 маягтад эрүүл ахуй гэх тухайн иргэний нэр дээр нийгмийн даатгалын шимтгэл төлөгдөөгүй, шалгуурыг хангаагүй.

**Налайх хангамжийн төв ОНӨААТҮГ**

7	Багц 3. Төмс, хүнсний ногооны багц	Эрдэнэ энх трейд ХХК	170.4	18.1 . в	Эрүүл ахуйч нь 2-оос доошгүй жил ажилласан туршлагатай байх, тухайн байгууллагын үндсэн ажилтан байх	Туршлагыг нотлох баримт ирүүлээгүй. Мөн үндсэн ажилтан биш хөдөлмөрийн гэрээгээр ажиллах гэрээтэй.
				12.1 . ё-9	Нийгмийн даатгалын байгууллагын НД-7, 8 маягтыг 2021 оны 03 дугаар сараас 2021 оны 09 дүгээр сарыг дуустал ирүүлэх	Шаардсан материалыг ирүүлээгүй.
				18.2 . ё	Хүнсний агуулахын хувьд Онцгой байдлын албанаас олгосон ажлын байрны дүгнэлтийн хуулбар ирүүлэх	Шаардсан материалыг ирүүлээгүй.
					Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт ирүүлэх	Шаардсан материалыг ирүүлээгүй.

**Нийт 2 ОНӨААТҮГ 4,660.1 сая төгрөгийн 7 багцад 2-3 төрлийн шалгуур үзүүлэлтийг хангаагүй оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан.**